



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНС, 2005-2017

Улаанбаатар
2018 он



“МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНС 2005 – 2017”

танилцуулгатай холбоотой мэдээлэл болон санал хүсэлт байвал доорх хаягаар холбогдоно уу.

Хянасан: Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга А.ДЭМБЭРЭЛ

Боловсруулсан: Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын статистикч Ю.БАТЗОРИГТ

Олон нийттэй харилцах хэлтэс:

Онлайн: <http://web.nso.mn/onlinechat/index.php>

Утас: 1900-1212

Холбогдох мэргэжилтэн:

Утас: 51-261559 /Ю.БАТЗОРИГТ/

Цахим хаяг: Batzorigt@nso.mn

Хаяг: Засгийн газрын III байр,
Бага тойруу – 44,
Улаанбаатар – 11,
Монгол Улс

Вэб хаяг: www.nso.mn, www.1212.mn

АГУУЛГА

НЭГ. ОРШИЛ.....	3
ХОЁР. МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНСНЫ 2005-2017 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛЭЭРХ ТАНИЛЦУУЛГА.....	4
2.1. Дотоодод ашигласан олборлолт	4
2.2. Импорт, экспорт, биет хэмжээгээр.....	5
2.3. Худалдааны тэнцэл, биет хэмжээгээр	6
2.4. Материалын шууд орц.....	7
2.5. Материалын дотоодын хэрэглээ	7
2.6. Материал багтаамж, нөөцийн бүтээмж	8
2.7. Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ.....	8
ГУРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ	9
ХАВСРАЛТ	0

НЭГ. ОРШИЛ

НҮБ-ын Статистикийн Комиссын 43-р чуулганаар "Байгаль орчин, эдийн засгийн дансны систем-Ерөнхий хүрээ 2012" олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичгийг баталж, гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон.

ҮСХ нь 2014 оноос БОЭЗДС-ийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд анхаарч тус хүрээний биет урсгалын дансны эхний данс болох "Материалын урсгалын данс"-ыг 2005-2013 оны гүйцэтгэлээр анх удаа туршилтаар байгуулсан. Энэхүү туршилт тооцоонд үндэслэн 2015 онд "Материалын урсгалын дансыг байгуулах аргачлал"-ыг боловсруулж, ҮСХ-ны даргын 2015 оны А/77 тоот тушаалаар баталж мөрдөж байсан.

Манай улсад олборлодог металлуудыг хүдэрт шилжүүлэх үндэсний хөрвүүлэх итгэлцүүрийг 2017 онд "Материалын урсгалын данс, 2015-2016" судалгаагаар тогтоож, дээрх аргачлалыг ҮСХ-ны даргын 2018 оны А/64 тоот тушаалаар шинэчлэн баталж, шинэчлэгдсэн аргачлалаар уг дансыг 2005-2017 оны гүйцэтгэлээр шинэчлэн байгууллаа.

Материалын урсгалын данс нь хуучны материалын болон эрчмийн балансын ойлголт дээр үндэслэгдсэн данс юм. Материалын урсгалын дансыг тогтмол давтамжтайгаар байгуулснаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНСНЫ 2005-2017 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛЭЭРХ ТАНИЛЦУУЛГА

2.1. Дотоодод ашигласан олборлолт


Монгол Улс 2017 онд нийт 236.8 сая тонн материал байгалиас олборлож, эдийн засгийн үйл ажиллагаанд ашигласан байна. Энэ нь 2005 оноос 117.5 сая тонн (2.0 дахин), 2016 оноос 15.7 сая тонн (7.1%) – оор өсжээ.

Хүснэгт 1. Дотоодод ашигласан олборлолт, материалын ангиллаар, мян.тонн

	2005	2016	2017	2017/2005		2017/2016	
				зөрүү	хувь	зөрүү	хувь
Нийт	119 219.4	221 087.3	236 750.7	117 531.3	2.0	15 663.5	107.1
Биомасс	34 555.7	68 461.4	73 141.1	38 585.5	2.1	4 679.7	106.8
Металлын хүдэр	73 421.9	111 560.2	110 987.1	37 565.2	1.5	- 573.1	99.5
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	2 953.2	4 225.8	4 272.6	1 319.4	1.4	46.8	101.1
Эрчим хүчний материал	8 288.7	36 839.9	48 349.9	40 061.2	5.8	11 510.0	131.2

Дотоодод ашигласан олборлолтын 2005-2017 оны үр дүнгээс харахад биомасс болон металлын хүдрийн олборлолт дотоодын олборлолтод хамгийн өндөр хувийн жинг эзэлж байна. Энэ нь манай улсын малын тоо толгой, тэдгээрийн байгалиас хэрэглэж байгаа өвс тэжээлийн хэмжээ болон уул уурхай салбарын хөгжилтэй холбоотой. Мөн эрчим хүчний дотоод олборлолтын хэмжээ 2017 онд 2005 оноос 13.5 пункт, өмнөх оноос 3.8 пунктээр өссөн нь нүүрсний олборлолт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Зураг 1. Дотоодод ашигласан олборлолтын бүтэц, материалын ангиллаар, дүнд эзлэх хувиар



2.2. Импорт, экспорт, биет хэмжээгээр


Манай улс 2017 онд 3.4 сая тонн материал импортолсон нь 2005 оноос 1.7 сая тонн (2.0 дахин), 2016 оноос 226.0 мян.тонн (7.2%) – оор нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Импорт, материалын ангиллаар, мян.тонн

	2005	2016	2017	2017/2005		2017/2016	
				зөрүү	хувь	зөрүү	хувь
Нийт	1 650.7	3 137.8	3 364.0	1 713.4	203.8	226.2	107.2
Биомасс	430.7	731.7	587.8	157.02	136.5	-143.9	80.3
Металлын хүдэр	181.0	413.4	602.0	421.0	332.5	188.6	145.6
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	335.2	627.4	455.3	120.1	135.8	-172.1	72.6
Эрчим хүчний материал	599.7	1 186.1	1 527.0	927.3	254.6	340.9	128.7
Бусад	104.0	179.1	192.0	88.0	184.6	12.9	107.2

Материалын төрлөөр авч үзвэл, 2017 онд 2005 оноос бүх материалын импортын хэмжээ нэмэгдэж, 2016 оноос металлын хүдэр, эрчим хүчний материал, бусад бүтээгдэхүүний импорт нэмэгдсэн хэдий ч биомасс, металл бус эрдэс бүтээгдэхүүний импорт 19.7 – 27.4 хувиар буурчээ.

Зураг 2. Импортын бүтэц, материалын ангиллаар, дүнд эзлэх хувиар



Эрчим хүчний материалын импорт хамгийн өндөр хувийг эзэлсэн хэвээр байна (Зураг 2).


Манай улс 2017 онд 42.9 сая тонн материал экспортолсон нь 2005 оноос 39.4 сая тонн (12.3 дахин), 2016 оноос 7.6 сая тонн (21.4%) – оор нэмэгджээ. Экспортын хэмжээ 2005 оноос 39.4 сая тонн (12.3 дахин) – оор нэмэгдэхэд металлын хүдрийн экспорт 7.1 сая тонн (9.4 дахин), эрчим хүчний материалын экспорт 32.8 сая тонн (15.3 дахин) – оор нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Экспорт, материалын ангиллаар, мян.тонн

	2005	2016	2017	2017/2005		2017/2016	
				зөрүү	хувь	зөрүү	хувь
Нийт	3 475.7	35 305.1	42 872.9	39 397.1	1 233.5	7 567.7	121.4
Биомасс	42.4	197.0	218.9	176.5	516.6	21.9	111.1
Металлын хүдэр	838.1	7 941.5	7 897.6	7 059.5	942.3	- 43.9	99.4
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	330.1	248.9	319.3	- 10.8	96.7	70.4	128.3
Эрчим хүчний материал	2 254.2	26 915.9	34 435.4	32 181.2	1 527.6	7 519.5	127.9
Бусад	11.0	1.9	1.7	- 9.3	15.5	- 0.2	88.7

Эрчим хүчний материалын экспорт 2016 онд нийт экспортод хамгийн өндөр хувь буюу 76.2 хувийг эзэлж байсан бол 2017 онд нүүрсний экспорт нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ үзүүлэлт хэвээр хадгалагдаж, экспортод эзлэх хувь 4.1 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 3. Экспортын бүтэц, материалын ангиллаар, дүнд эзлэх хувиар



2.3. Худалдааны тэнцэл, биет хэмжээгээр

Мөнгөн дүнгээр илэрхийлсэн, гадаад худалдааны тэнцлийг экспортоос импортыг хасаж тооцдог бол биет хэмжээгээрх гадаад худалдааны тэнцлийн хувьд эсрэгээр нь импортоос экспортыг хасна.

Худалдааны тэнцэл 2005-2017 онд алдагдалтай гарсан байна. Энэ нь манай улс импортоосоо илүү их материалыг экспортолж байна гэсэн үг юм.

Импортын хэмжээ 2017 онд 2005 оноос 2.0 дахин өссөн хэдий ч экспортын хэмжээ 12.3 дахин өссөн нь худалдааны тэнцлийн алдагдал 21.6 дахин нэмэгдэхэд хүргэсэн байна.

Хүснэгт 4. Худалдааны тэнцэл, мян.тонн

	2005	2016	2017	2017/2005		2017/2016	
				зөрүү	хувь	зөрүү	хувь
Худалдааны тэнцэл	-1 825.1	-32 167.3	-39 508.8	-37 683.7	2 164.8	-7 341.5	122.8
Импорт	1 650.7	3 137.8	3 364.0	1 713.4	203.8	226.2	107.2
Экспорт (-)	3 475.7	35 305.1	42 872.9	39 397.1	1 233.5	7 567.7	121.4

2.4. Материалын шууд орц

Материалын шууд орцыг дотоодод ашигласан материалын олборлолт болон импортлосон материалын нийлбэрээр тооцно.

Материалын орцын хэмжээ 2017 онд 240.1 сая тонн болж, 2005 оноос 119.2 сая тонн (98.7%), 2016 оноос 15.9 сая тонн (7.1%) – оор нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Материалын шууд орц, мян.тонн

	2005	2016	2017	2017/2005		2017/2016	
				зөрүү	хувь	зөрүү	хувь
Материалын шууд орц	120 870.1	224 225.1	240 114.8	119 244.7	198.7	15 889.7	107.1
Дотоодод ашигласан олборлолт	119 219.4	221 087.3	236 750.7	117 531.3	198.6	15 663.5	107.1
Импорт	1 650.7	3 137.8	3 364.0	1 713.4	203.8	226.2	107.2

2.5. Материалын дотоодын хэрэглээ

Эдийн засаг дахь материалын дотоодын хэрэглээг материалын шууд орцоос экспортыг хасаж тооцно.

Манай улсын эдийн засаг дахь материалын хэрэглээ 2017 онд 197.2 сая тонн болж, 2005 оноос 79.8 сая тонн (68.0%), 2016 оноос 8.3 сая тонн (4.4%) – оор нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Материалын дотоодын хэрэглээ, мян.тонн

	2005	2016	2017	2017/2005		2017/2016	
				зөрүү	хувь	зөрүү	хувь
Материалын дотоодын хэрэглээ	117 394.4	188 919.9	197 241.9	79 847.6	168.0	8 322.0	104.4
Материалын шууд орц	120 870.1	224 225.1	240 114.8	119 244.7	198.7	15 889.7	107.1
Экспорт (-)	3 475.7	35 305.1	42 872.9	39 397.1	1 233.5	7 567.7	121.4

Материалын дотоодын хэрэглээнд металлын хүдэр болон биомассын эзлэх хувийн жин өндөр байна.

2.6. Материал багтаамж, нөөцийн бүтээмж

Материал багтаамж: Тухайн улсын эдийн засгийн материалын үр ашгийг тодорхойлох үзүүлэлт бөгөөд материалын дотоодын хэрэглээг ДНБ-д харьцуулж тодорхойлно.

Нөөцийн бүтээмж: Энэ үзүүлэлтийг материалын багтаамжийн урвуу буюу ДНБ-ийг материалын дотоодын хэрэглээнд харьцуулж тодорхойлно. Нөөцийн бүтээмж нь зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд эдийн засаг дахь бараа, үйлчилгээний үйлдвэрлэлд нөөцийг хэрхэн үр ашигтай ашигласныг харуулна. Хэрвээ ДНБ нь материалын дотоодын хэрэглээнээс илүү өсвөл нөөцийн бүтээмж өссөнийг харуулна.

Хүснэгт 7. Материал багтаамж, нөөцийн бүтээмж

	2005	2016	2017	2017/2005		2017/2016	
				зөрүү	хувь	зөрүү	хувь
Материал багтаамж, кг/сая төг	38 599	7 890	7 071	-31 528	18	- 820	89.6
Нөөцийн бүтээмж, төг/кг	26	127	141	116	546	15	111.6

Манай улс 2016 онд 7.9 тонн материалаар 1 сая төгрөгийн ДНБ-ийг үйлдвэрлэсэн бол 2017 онд 7.1 тонн материалаар 1 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэж, нөөцийн бүтээмж талаас нь авч үзвэл, манай улс 2016 онд 1 кг материалаар 127 төгрөгийн нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн бол 2017 онд 1 кг материалаар 141 төгрөгийн нэмэгдэл өртөг үйлдвэрлэжээ.

2.7. Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ

Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ нь “Тогтвортой хөгжлийн зорилго – 2030” хөтөлбөрийн нэг чухал үзүүлэлт юм.



Манай улсын нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ 2017 онд 62.6 тонн болж, 2005 оноос 6.3 тонноор, 2016 оноос 1.4 тонноор нэмэгджээ.

ГУРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Материалын урсгалын дансыг тогтмол байгуулж, материалын үр ашиг, харьцааг тодорхойлох нь бодлого боловсруулах, шийдвэр гаргахад хэрэгцээтэй мэдээлэл болно.

Байгалийн нөөцийн ашиглалт, түүний бүтээмж, нөөцийн хараат байдал зэргийг хэмжсэн үзүүлэлтийг дан ганц байгалийн нөөцийн менежментийг үр ашигтай явуулахад бус цаашилбал улс орнуудын хооронд харьцуулалт хийхэд ашигладаг.

Цаашид олон улсад зэрэгцүүлэх материалын урсгалын үзүүлэлтүүдийг гүнзгийрүүлэн судлах, тооцох болон эдийн засаг, нийгмийн бусад үзүүлэлтүүдтэй холбож эконометриксийн харилцан хамаарал, нөлөөллийн дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Дотоодод ашигласан олборлолт, материалын ангиллаар, мян.тонн, 2005–2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт	119 219.4	121 135.7	116 889.2	114 602.8	107 611.8	104 849.9	116 472.8	121 121.8	152 862.4	174 346.3	192 366.8	221 087.3	236 750.7
Биомасс	34 555.7	38 445.0	43 138.0	45 221.6	46 400.2	37 017.7	40 862.2	45 488.6	50 139.5	57 878.7	62 097.8	68 461.4	73 141.1
Металлын хүдэр	73 421.9	71 693.3	61 336.4	56 225.8	46 197.6	40 523.1	41 121.8	44 139.8	61 678.2	81 586.5	97 789.9	111 560.2	110 987.1
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	2 953.2	3 050.2	3 536.1	3 170.3	1 543.7	1 705.6	3 131.3	2 337.0	11 041.3	8 741.3	6 894.2	4 225.8	4 272.6
Эрчим хүчний материал	8 288.7	7 947.2	8 878.6	9 985.2	13 470.2	25 603.6	31 357.5	29 156.4	30 003.5	26 139.8	25 584.9	36 839.9	48 349.9

Хүснэгт 2. Импорт, материалын ангилалаар, мян.тонн, 2005-2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт	1 650.7	1 853.2	2 535.9	3 156.0	2 631.2	3 238.5	4 584.2	5 118.4	5 284.0	4 955.9	4 083.6	3 137.8	3 364.0
Биомасс	430.7	447.8	540.2	723.4	566.9	626.6	567.0	613.7	599.6	623.7	587.0	731.7	587.8
Металлын хүдэр	181.0	208.4	347.9	528.5	334.9	486.9	1 036.3	977.5	824.4	757.4	575.7	413.4	602.0
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	335.2	403.8	661.3	828.0	747.6	1 018.3	1 604.7	2 240.3	2 174.1	2 086.2	1 433.2	627.4	455.3
Эрчим хүчний материал	599.7	681.3	851.5	912.1	811.9	898.4	1 049.8	939.1	1 413.9	1 231.6	1 270.8	1 186.1	1 527.0
Бусад	104.0	112.0	135.0	164.0	169.8	208.4	326.3	347.8	272.0	257.0	216.9	179.1	192.0

Хүснэгт 3. Экспорт, материалын ангилалаар, мян.тонн, 2005-2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт	3 475.7	3 890.7	4 833.7	6 500.1	10 197.2	21 720.6	28 754.7	29 172.4	27045.4	28753.8	22705.8	35305.1	42872.9
Биомасс	42.4	64.1	68.7	64.1	75.5	83.3	88.8	83.6	99.2	122.8	123.7	197.0	218.9
Металлын хүдэр	838.1	1 046.2	1 010.7	1 752.2	2 360.1	4 287.7	6 527.4	7 143.9	7 523.1	7 871.6	6 711.5	7 941.5	7 897.6
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	330.1	356.1	363.0	354.1	314.4	410.1	407.3	429.1	339.1	314.2	290.6	248.9	319.3
Эрчим хүчний материал	2 254.2	2 415.5	3 384.9	4 324.2	7 441.2	16 938.8	21 730.5	21 515.1	19 082.6	20 444.0	15 579.1	26 915.9	34 435.4
Бусад	11.0	8.8	6.4	5.4	6.1	0.7	0.8	0.7	1.4	1.2	0.9	1.9	1.7

Хүснэгт 4. Худалдааны тэнцэл, мян.тонн, 2005-2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Худалдааны тэнцэл	-1 825.1	-2 037.4	-2 297.8	-3 344.1	-7 566.0	-18482.1	-24170.6	-24054.0	-21761.4	-23797.9	-18622.2	-32167.3	-39508.8
Импорт	1 650.7	1 853.2	2 535.9	3 156.0	2 631.2	3 238.5	4 584.2	5 118.4	5 284.0	4 955.9	4 083.6	3 137.8	3 364.0
Экспорт (-)	3 475.7	3 890.7	4 833.7	6 500.1	10 197.2	21 720.6	28 754.7	29 172.4	27 045.4	28 753.8	22 705.8	35 305.1	42 872.9

Хүснэгт 5. Материалын шууд орц, мян.тонн, 2005-2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Материалын шууд орц	120870.1	122988.9	119425.1	117758.8	110243.0	108088.4	121057.0	126240.2	158146.4	179302.2	196450.4	224225.1	240114.8
Дотоодод ашигласан олборлолт	119 219.4	121 135.7	116 889.2	114 602.8	107 611.8	104 849.9	116 472.8	121 121.8	152 862.4	174 346.3	192 366.8	221 087.3	236 750.7
Импорт	1 650.7	1 853.2	2 535.9	3 156.0	2 631.2	3 238.5	4 584.2	5 118.4	5 284.0	4 955.9	4 083.6	3 137.8	3 364.0

Хүснэгт 8. Материалын дотоодын хэрэглээ, мян.тонн, 2005-2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Материалын дотоодын хэрэглээ	117394.4	119098.2	114591.3	111258.8	100045.8	86 367.8	92 302.3	97 067.9	131101.1	150548.3	173744.6	188919.9	197241.9
Материалын шууд орц	120 870.1	122 988.9	119 425.1	117 758.8	110 243.0	108 088.4	121 057.0	126 240.2	158 146.4	179 302.2	196 450.4	224 225.1	240 114.8
Экспорт (-)	3 475.7	3 890.7	4 833.7	6 500.1	10 197.2	21 720.6	28 754.7	29 172.4	27 045.4	28 753.8	22 705.8	35 305.1	42 872.9

Хүснэгт 9. Материал багтаамж болон нөөцийн бүтээмж, 2005-2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Материал багтаамж, кг/сая төг	38 598.7	29 570.8	23 118.7	16 971.6	15 180.0	8 852.3	7 006.5	5 816.5	6 837.4	6 773.2	7 505.0	7 890.4	7 070.7
Нөөцийн бүтээмж, төг/кг	26	34	43	59	66	113	143	172	146	148	133	127	141

Хүснэгт 10. Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ, тонн, 2005-2017 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ, тонн	46.3	46.4	44.0	42.1	37.2	31.5	33.1	34.2	45.2	50.8	57.4	61.2	62.6